

Бидний үр хүүхэд Аврагчийн нүүрийг харах болно

Хүүхдийн Хэсгийн саяхан чөлөөлөгдсөн ерөнхий ерөнхийлөгч  
Шерил К.Лант

Өсвөр үеийнхээ хүүхэд залуучуудыг Аврагчид аваачих нь эцэг эхчүүд, удирдагчид бидний ариун үүрэг мөн.

Хэдэн жилийн өмнө би бяцхан багачуудад сайн мэдээний богинохон хичээлийг хэрхэн заах талаар хүүхдийн хэсгийн удирдагчдад заасан юм. Удирдагчдын нэг нь бяцхан хүүгээ өвөр дээрээ суулгасан байлаа. Би Аврагчийн зургийг бариад хэрхэн заах вэ гэдгийг үзүүлэн Түүний тухай ярьж хичээлээ эхлэв. Бяцхан хүү ээжийнхээ өвөр дээрээс бууж миний өөдөөс тоодгонон алхаж ирээд зургийг анхааралтай ажигласнаа нүүрэнд нь гараа хүргэв. Энэ үед би түүнээс “Энэ хэн бэ?” гэж асуухад тэрээр нүүр дүүрэн инээмсэглэн “Есүс” гэж хариулсан юм.

Өөрийнхөө нэрийг хүртэл хэлж чадахгүй болов уу гэмээр тэр бяцхан хүү Аврагчийн зургийг таньж нэрийг нь мэдэж байв. Түүний гайхалтай хариултыг сонсоод Аврагчийн хэлсэн, “та нар өөрсдийн тэвчээрээр бодгалиудаа олж авч болохын тулд, Их Эзэний нүүрийг ямагт эрэлхийл мөн та нар мөнх амьдралтай байх болно” (С ба Г 101:38) гэсэн үгс санаанд минь орж ирсэн юм.

Аврагчийн нүүрийг эрэлхийл гэдэг нь ямар утгатай юм бол оо? Мэдээж энэ нь зөвхөн Түүний зургийг танихаас илүү утга учиртай байж таарна. Христийн Өөрийг нь эрэлхийл гэсэн санаа нь Тэр хэн болох, Тэр бидний төлөө юу хийсэн, биднийг юу хийгээсэй гэж хүсдэгийг олж мэд гэсэн санаа юм. Бид зөвхөн итгэл,ажил үйлдсээрээ Христэд ойртож эцэст нь Түүний нүүрийгхарах болно. Энэ нь бидний насан туршийн хүчин чармайлтаар биеллээ олно. Тэгвэл бид дараагийн амьдралд Түүний нүүрийг харахын тулд энэ амьдралдаа Түүнийг хэрхэн эрэлхийлэх вэ?

Бидэнд Аврагчийн дүр төрхийг энэ амьдралдаа харсан хүмүүсийн тухай цэдэг 3 Нифай дээр байдаг билээ. Бид Түүний дүр төрхийг одоо харж чадахгүй ч тэр хүмүүсийн туршлагаас суралцаж болно. Аврагч нас барсныхаа дараа эдгээр хүмүүст харагдаж, тэдэнд зааж, тэднийг адисалсан юм. Тэгээд “. . . . мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэдний бяцхан хүүхдүүд авчрагдахыг зарлиг болгов.” (3 Нифай 17:11)

Энэхүү өсөж буй бидний үр удам Түүний нүүрийг бас Тэнгэрлэг Эцэгийннүүрийг харахын тулд тэднийг Аврагчид аваачих нь эцэг эхчүүд, удирдагчид бидний ариун үүрэг бөгөөд ингэснээр бид бас өөрсдийгөө аваачих болно.

Би дахин нэг асуулт асууя. Уруу таталтаар дүүрэн энэ дэлхийд бид үүнийг хэрхэн хийх вэ? 3 Нифайд гардаг эцэг эхчүүд Их Эзэнд үнэхээр их хайртай байсан. Тэд итгэгч байсан. Тэд Есүсийн үйлдсэн гайхамшигт итгэдэг байв. Мөн тэд хүүхдүүддээ хайртай байлаа. Тэд Эзэний үгийг сонсохоор хамтдаа цугларч мөн хүүхдүүдээ Түүнд авчир гэсэн зарлигийг дуулгавартай дагасан юм.

Тэд хүүхдүүдээ авчирсны дараа Христ эцэг эхчүүдэд өвдөг сөгдөхийг зарлиг болгосон. Дараа нь Тэр бид бүхний төлөө хийсэн зүйлээ бас тэдний төлөө хийсэн юм. Тэрээр Эцэгт хандан тэдний төлөө залбирсан бөгөөд Түүний үгсийг дүрслэхийн аргагүй “агуу хийгээд гайхамшигтай” (3 Нифай 17:16) байсан гэж тэмдэглэн үлдээсэн байдаг. Христэд ирж, Түүний Цагаатгалыг хүлээн зөвшөөрснөөр эцэг эхчүүд хүүхдүүдээ “авчрах” бүхий л шаардлагатай зүйлд хүчирхэгжсэн юм.

Христ эцэг эхчүүдээс хийхийг хүссэн өөр нэг зүйл 3 Нифай 22:13-т гардаг юм. “. . . Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно, мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно.”

Нифайчууд Аврагчтай хамт байсан туршлагаараа үр хүүхдүүддээ Түүний тухай заасан юм. Тэд хүүхдүүддээ Их Эзэнийг хайрлахыг, сайн мэдээний дагуу хэрхэн амьдрахыг заасан юм. Тэд үнэхээр маш сайн заасан учир тэр нутаг 200 жилийн турш зөв шударга, амар амгалан оршин тогтсон юм (4 Нифай 1:1--22-ыг үз).

Одоо би та бүхнээс эргэн тойрондоо байгаа хайртай хүмүүсээ харахыг хүсч байна. Бидний гэр бүлийнхэн маань бидэнд хамгийн чухал хүмүүс. Та өөрийнхөө гэр бүлтэйгээ мөнхөд хамт байхыг юу юунаас илүү хүсч байгаа гэдэгт би итгэлтэй байна. 3 Нифайд гардаг түүх нь бидэнд загвар болж байгаа учраас бидэнд хүүхдүүдээ Түүн дээр авчрахад маань туслах болно. Учир нь энэ бол бидний дагах ёстой загвар юм. Нэгдүгээрт, бид бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэнээ мөн үр хүүхдүүдээ хайрлах ёстой. Хоёрдугаарт, Их Эзэнийг үргэлж эрэлхийлж, сайн мэдээний дагуу амьдрахыг хичээж үр хүүхдүүддээ зөв шударга үлгэр жишээ үзүүлэгч байх хэрэгтэй. Гуравдугаарт, сайн мэдээ болон үүний дагуу хэрхэн амьдрахыг үр хүүхдүүддээ заах ёстой.

Энэхүү загварыг дагах нь хүүхдүүдээ Аврагчид аваачих үйл явц юм. Энэ загварыг дахин нэг харцгаая. Эхлээд бид Их Эзэн болон гэр бүлээ хэрхэн хайрлахыг сурах

ёстой. Үүнийг хийхэд цаг хугацаа, туршлага. итгэл мөн нийгүүлсэнгүй үйлчлэл шаардлагатай. Бид Их Эзэний хайраар дүүрэн байвал бусдыг хайрлаж чадна. Тэрээр бидний юу хийж байгааг хараад уйлдаг байх, гэвч Тэр бидэнд хайртай, бидэнд туслахад үргэлж бэлэн байдаг. Ийм л замаар бид үр хүүхдээ хэрхэн хайрлахыг сурах болно.

Хоёрдугаарт, бид зөв зохистой үлгэр жишээ үзүүлэгч байх ёстой. Энэ ч бас нэг алхам юм. Хэрвээ бид үр хүүхдүүдээ Христэд очиж нүүрийг хараасай гэж хүсч байгаа бол өөрсдөө мөн харахын төлөө эрэлхийлэх нь чухал юм. Хүүхдүүдээ энэхүү замыг харуулахын тулд бид өөрсдөө замаа мэддэг байх ёстой. Үр хүүхдүүд маань биднийг дагадаг байхын тулд бид амьдралаа эмх цэгцтэй байлгах ёстой. Бид өөрсдөөсөө “ Хүүхдүүд маань миний нүүр өөд харах үедээ юу хардаг бол?” “Хэрхэн амьдарч байгааг минь тэд хараад Аврагчийн дүр төрхийг миний нүүрнээс хардаг болов уу?” гэж асууж болох юм.

Бидний хэн нь ч хүүдүүддээ төгс үлгэр жишээ үзүүлэгч байж чадахгүй гэдгийг санаарай. Гэвч бид зөв зохистой эцэг эх, удирдагчид байж чадна. Бид зөв зохистой байхыг хичээснээрээ өөрөө сайн үлгэр жишээ үзүүлж чаддаг. Бид заримдаа алдаж энэдэх боловч үргэлж хичээж чадна. Мөн Их Эзэн бидэнд туслах болно гэдэгт найдах хэрэгтэй. Түүнтэй хамт мөн Түүний тусламжтайгаар бид ямар хүн байх ёстой вэ гэдэг тал дээр хүчирхэгжиж чадна. Бид юу хийх ёстой юмаа хийж чадна.

Гуравдугаарт, бид хүүхдүүддээ судар болон бошиглогчдын үгсээс сайн мэдээний үнэнийг заан тэдэнд сүнсийг таньж, мэдрэхэд тусалснаар тэднийг Аврагчид авчрах болно. Бяцхан хүүхдүүд хүртэл үүрд мөнхийн зүйлсийн мөн чанарыг ойлгож, хүлээн зөвшөөрдөг. Тэд судруудад болон бошиглогчдод хайртай болдог. Тэд заяамал зөн билгээрээ сайн хүүхдүүд байхыг хүсдэг. Тэдний энэхүү тэнгэрлэг шижмийг нээлттэй байлгах нь бид тэдэнд хэрхэн туслахаас хамаарна. Ариун Сүнсний нөлөөг бууруулах зүйлсээс тэднийг хамгаалах нь бидний үүрэг мөн. Бид судраас тусламж, зааврыг олж чадна. Дараа нь бид хүүхдүүддээ хариултаа хэрхэн олж авахыг заах хэрэгтэй. Бид тэдэнд зөв зарчмуудыг зааж, эдгээр зарчмуудыг амьдралд хэрэгжүүлж сурахад нь туслах ёстой. Бид тэднийг Ариун Сүнс уруу чиглүүлж өгснөөр тэд сурч байгаа зүйлийнхээ үнэнийг мэдэж? хувийн гэрчлэлтэй болно. Бид Сайн мэдээний дагуу амьдарснаар ирэх баяр баяслыг мэдрэхэд тэдэнд тусалж чадна. Ингэснээр амьдралдаа итгэлийн болон дуулгавартай байдлын гуйвшгүй бат бөх суурийг тавихад бид хүүхдүүддээ туслах болно.

Мэдээж энэ бүх зүйлийг хийхэд амаргүй. Нифайчуудын цэдэгт өгүүлснээр гэр бүлүүд 200 жилийн турш амар амгалан амьдарсан гэдэг. Гэхдээ тэд маш их чармайсан нь лавтай. Үүнд асар их хөдөлмөр, тэсвэр тэвчээр, итгэл шаардагдах боловч үүнээс илүү чухал зүйл, илүү шагнал гэж үгүй. Их Эзэн үр хүүхдүүдэд

маань биднээс ч илүү хайртай учраас Тэр бидэнд туслах болно.

Тэрээр нифайчуудын хүүхэд нэг бүрийг адисалж, залбирсныг та нар санаж байгаа байх (3 Нифай 17:14--17, 21-ийг үз). Тэгээд: “. . . тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.”

“Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг тэд үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв, мөн тэд доош ирж мөн багачуудыг эргэн тойрон хүрээлж, мөн тэр галаар эргэн тойрондоо хүрээлэгдсэн байв, мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав” (3 Нифай 17:23-24).

Өнөө үед бидний хүүхдүүд үүн шиг адислалуудыг хэрхэн авч чадах вэ? Ахлагч М.Расселл Баллард хэлсэн нь: “Хүүхдүүд өөрийгөө хэн бэ гэдгээ мэдэхэд нь туслахын тулд, тэднийг хайр, итгэлийн галаар хүрээлж байхын тулд Бурхан биднийг сонгосон учраас үнэ цэнэтэй хүүхдүүдтэй болсон бид тэднийг удирдан залах ариун үүрэгтэй хүмүүс гэдэг нь ойлгомжтой байна” (“Behold Your Little Ones,” *Tambuli*, 1994 оны 10-р сар, 40).

Ах, эгч нар аа, бид бол хүүхдүүдээ адислахаар Бурханаас илгээгдсэн тэнгэр элчүүд бөгөөд бид тэдэнд сайн мэдээний зарчмуудыг зааж, гэр орноо баяр баяслаар дүүрэн байлгаснаар тэднийг нэгэн өдөр Аврагчийн нүүрийг харахад тусалж чадна. Бид хамтдаа Түүнийг таньж, хайр болон адислалыг нь мэдрэх болно. Түүний тусламжтайгаар бид Эцэгийнхээ оршихуйд эргэн очих болно. Хэрвээ бид Түүний заасан зүйлд дуулгавартай, итгэлтэй, хичээнгүй байж чадвал энэ бүх зүйлийг хийж чадна.

“Үнэнээр Их Эзэн ийн хэлдэг: Мөнхүү улиран тохиох дор нүглээ орхиж мөн надад ирдэг, мөн миний нэрийг дууддаг, мөн дуу хоолойг минь дуулгавартай дагадаг, мөн зарлигуудыг минь сахьдаг бодгаль болгон миний нүүрийг харж мөн намайг байдгийг мэдэх болно” (С ба Г 93:1)

Ах, эгч нар аа, Бурхан амьд, Есүс Христ бол Түүний Хүү, бидний Аврагч, Гэтэлгэгч гэдгийг би мэднэ. Тэрээр бидийг Өөртөө ирэхийг урьсан бөгөөд хүүхдүүдээ авчрахыг зарлиг болгосон, тэгснээрээ бид хамтдаа Түүний нүүрийг харж Тэнгэр дэх Эцэг болон Түүнтэй хамт мөнхөд хамт амьдрах болно. Энэхүү агуу адислалыг хүлээж авахын тулд бүгдээрээ хөдөлмөрлөхийн төлөө би залбирч байна. Есүс Христийн нэрээр амен.